



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 4/162

Улаанбаатар хот

Г

Г

Журам батлах тухай

Монгол Улсын "Дээд боловсролын тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, МУИС-ийн Дүрмийн 4.5.8.3 дахь заалт, Захиргааны зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн МУИС-ийн Стратегийн төлөвлөгөө /2016-2024/-г хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1."Судалгааны санхүүжилтээс Монгол Улсын Их Сургуульд шууд бус зардлын хуримтлал бүрдүүлэхэд баримтлах журмыг хавсралтаар баталж, 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2.Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг асуудал эрхэлсэн дэд захирал (Б.Болдгив, Ч.Нарантуяа, Г.Баярмагнай, О.Мөнхбат), Төгсөлтийн дараах сургуулийн захирал (Б.Отгонтөгс), Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний албаны дарга (В.Батцэнгэл) наарт даалгасугай.

а) Улсын төслийн
зардалт т.м.)

д) Зөвлөх чадлыг

1.3.Шинэ ЗАХИРАЛ

шардлагдах байгууллагын
холбогдох урсац зардал
санхүү, бүртгэлийн үйлчилгээ, узүүлэх, хамтран зохицуулж гаргаж байгуулах
холбогдох яам, шентлаг, тазрууудад хөндөн албан бичиг хургуулах, зөвлөгөө
өтөх төслийн издээсплийн сан бурдлуулж МУИС тогтолцоу үзүүлийн




Р.БАТ-ЭРДЭНЭ

My document.Tushaal.2016.June

ЭЦС - Асуудлын төслийн зөвлөлтийн

20161073



**СУДАЛГААНЫ САНХҮҮЖИЛТЭЭС МОНГОЛ УЛСЫН
ИХ СУРГУУЛЬД ШУУД БУС ЗАРДЛЫН ХУРИМТЛАЛ
БҮРДҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг ундэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсийн санхүүжилт, захиалгаар МУИС дангаар болон хамтран хэрэгжүүлэх эрдэм шинжилгээний төсөл, хөтөлбөр, гэрээт болон сонгон шалгаруулалт (тендер)-ын ажил (цаашид “төсөл” гэнэ), лицензийн гэрээ зэргээс шимтгэл тооцох замаар МУИС-д шууд бус зардлын хуримтлал бүрдүүлж, түүнийг зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. “Төсөл” гэдэгт МУИС-ийн багш, ажилтан, суралцагчдын оролцон гүйцэтгэж буй дараах үйл ажиллагааг ойлгоно. Үүнд:

- Олон улсын болон гадаадын аль нэг санхүүжүүлэгч байгууллага, хувь хүмүүсийн санхүүжилттэй төсөл, хөтөлбөр,
- Гадаадын их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтарсан төсөл, хөтөлбөр,
- Дотоодын байгууллагуудтай хамтарсан төсөл, гэрээт ажил, сонгон шалгаруулалтын болон даалгаварт ажил,
- Улсын захиалгат ажил (сэдэвт ажил, төсөл, инновацийн төсөл, зэхэц ажил Г.М.),
- Зөвлөх үйлчилгээ.

1.3. Шимтгэл тооцсон төслийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах байгууллагын дэмжлэгийг (судалгаа явуулах орон зайд, түүнтэй холбоотой урсгал зардал, мэдээллийн технологийн үйлчилгээ зэргээр хангах, санхүү, бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах гэрээ байгуулах, холбогдох яам, агентлаг, газруудад хандсан албан бичиг хүргүүлэх, зөвлөгөө өгөх, төслийн мэдээллийн сан бүрдүүлэх) МУИС тогтмол үзүүлнэ.

Хоёр.Шууд бус зардлын хуримтлал бүрдүүлэх

1.Хуримтлалыг энэхүү журмын 1.2-д заасан төслөөс шимтгэл тооцох замаар бүрдүүлэх бөгөөд шимтгэлийн хувийг тогтоохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:

2.1.1.Төслийг хамтран хэрэгжүүлэгч, захиалагч, эсвэл санхүүжүүлэгч байгууллага, хувь хүн болон МУИС-ийн хооронд хамтын ажиллагааны гэрээг байгуулах ажлыг төслийн удирдагч, зохицуулагч буюу гүйцэтгэгчид зохион байгуулж баталгаажуулна.

2.1.2.Төсөл хэрэгжүүлэх байгууллага, төслийн удирдагч, зохицуулагч, гүйцэтгэгч нь тухайн төслийн төсөвт шууд бус зардлыг (бусад зардал, захиргааны зардал, байгууллагын шимтгэл, болзошгүй зардал г.м. хэлбэрээр) тусгаж төсөвлөх үүрэгтэй.

2.1.3.Шимтгэл нь төслийн нийт төсвийн 5 хувиас багагүй, 15 хувиас илүүгүй байна. МУИС дангаараа санхүүжүүлсэн дотоод төслийн санхүүжилтээс шимтгэлийн хувь тооцохгүй. Санхүүжүүлэгч байгууллагаас шууд бус зардлын шимтгэл төлөхийг тусгайлан хориглосон, онцгой нөхцлөөр гэрээ байгуулсан тохиолдолд шимтгэлийн хувь тооцохгүй.

2.1.4.Төслийн гэрээнд шимтгэлийн хувь хэмжээг тусгайлан заасан бол гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.1.5.Төслийн гэрээнд худалдан авах багаж тоног төхөөрөмжийг МУИС-ийн өмч болгохоор тусгасан, эсвэл магистрант, докторант, залуу судлаачдад тэтгэлэг, ажлын хэлс олгохоор заасан тохиолдолд, тэдгээрт зарцуулах мөнгөн дүнг төслийн нийт мөнгөн дүнгээс хасч, үлдсэн хэсгээс шимтгэлийг тооцно.

Гурав.Хуримтлалын хуваарилалт ба зарцуулалт

3.1.Төслийн санхүүжилтээс сүутгасан шимтгэлийн 50 хувийг МУИС-ийн эрдэм шинжилгээ, инновацийн дансанд хуримтлуулна. Тухайн санхүүгийн жилийн зарцуулалт нь нийт хуримтлалын сангийн 70 хувиас хэтрэхгүй байх бөгөөд дараах хэлбэрээр зарцуулна. Үүнд:

3.1.1.Багш, ажилтан, ахисан түвшний суралцагчдын өндөр чансаатай эрдэм шинжилгээний бүтээлийг жилд нэг удаа, МУИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн бодлогын зөвлөлөөс шалгаруулан урамшуулах,

3.1.2.Сургалт, судалгааны орчин, материаллаг нөхцлийг сайжруулах,

3.1.3.Гарааны компанийг дэмжих, санхүүжүүлэх,Д0072 9104399

3.1.4.МУИС-ийн оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийхэд зарцуулах,

3.1.5.Энэхүү журмын 1.3-д заасны дагуу судалгааг дэмжих, төслийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай байгууллагын болон захиргааны дэмжлэг үзүүлэхэд зарцуулах.

3.2.Төслийн санхүүжилтээс МУИС-ийн эрдэм шинжилгээ, инновацийн дансанд хуримтлуулсан шимтгэлийн 50 хувийг төслийн удирдагч буюу зохицуулагчийн харьялагдах бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төв зэрэг нэгжид нь санхүүгийн жилийн эцэст шилжүүлнэ. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төв зэрэг нэгж гэрээ хийж хуримтлуулсан шимтгэлийн 50 хувийг МУИС-ийн эрдэм шинжилгээ, инновацийн дансанд санхүүгийн жилийн эцэст шилжүүлнэ. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төв зэрэг нь хуримтлалыг дараах хэлбэрээр зарцуулна. Үүнд:

3.2.1.Хуримтлал бүрдүүлсэн багш, ажилтан, ахисан түвшний суралцагчдын сургалт, судалгааны үйл ажиллагааг дэмжих, урамшуулах,

3.2.2.Хуримтлал бүрдүүлсэн судалгааны багийн сургалт, судалгааны орчин, материаллаг нөхцлийг сайжруулах,

3.2.3.Энэхүү журмын 1.3-д заасны дагуу судалгааг дэмжих, төслийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай байгууллагын болон захиргааны дэмжлэг үзүүлэхэд зарцуулах.

3.3.Төслийн удирдагч нь МУИС-тай тусгай гэрээ байгуулж, төслийн нийт төсвөөс гэрээнд заасан хэмжээний шимтгэлийг МУИС-ийн хуримтлалын дансанд шилжүүлж, үлдэгдэл төсвийг гэрээний дагуу бүрэлдэхүүн сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн данс руу шилжүүлж болно.

3.4.Тухайн жилд зарцуулах хуримтлалын төсвийг Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал МУИС-ийн захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж, захиран зарцуулна.

3.5.Бүрэлдэхүүн сургууль, нэгжид хуваарилсан шимтгэлийг тухайн сургууль захиргааны зөвлөлөөрөө хэлэлцүүлж, энэхүү журмын 3.2-р заалтад дурьдсан үйл ажиллагааг дэмжих зориулалтаар зарцуулна.

3.6. Технологийг зах зээлд нэвтрүүлэх, түүнээс орсон ашгийг хуваарилах-тай холбогдсон харилцааг “МУИС-ийн технологи дамжуулах журам”-ын дагуу зохицуулна.

Дөрөв. Зарцуулалт гүйцэтгэлийн хяналт, урамшуулал

УХД0072 9104399

4.1. Хуримтлалын зарцуулалтын жилийн тайланг Эрдэм шинжилгээ, инноваци эрхэлсэн дэд захирал МУИС-ийн Захиргааны зөвлөлөөр, бүрэлдэхүүн сургуулийн захирал бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлөөр жилд нэг удаа хэлэлцүүлнэ.

4.2. Төслөөс суутгасан шимтгэлийг уг төслийг хэрэгжүүлсэн судлаач, судалгааны багийн МУИС-д оруулсан орлогод тооцно.

4.3. Сургуульд төслөөсөө шимтгэл байдлаар оруулсан орлогыг төслийн удирдагч, хүрээлэн, төвийн захирал, эрхлэгчийн хувьд үр дүнгийн гэрээний биелэлтэнд, бусад профессор, багшийн хувьд “МУИС-д профессор багш ажиллуулах журам”-ын дагуу эрдэм шинжилгээний ажлын ноогдолд тус тус оруулж тооцно.

4.4. Төслийн хүрээнд шинэ багаж, тоног төхөөрөмж, програм хангамж, лиценз худалдан авч МУИС-ийн өмчлөлд шилжүүлсэн тохиолдолд, тэдгээр эд зүйлсийг судалгаа, шинжилгээ, аж ахуйн гэрээт ажилд ашигласнаас олох орлогын 15 хүртэлх хувьтай тэнцэх урамшууллыг төслийн удирдагч, багийн гишүүдэд олгож болно.

4.5. Сургуультай гэрээ байгуулж, хэрэгжүүлээгүй төсөл, хөтөлбөрийг профессор багшийн судалгааны ажлын үнэлгээний биелэлтэнд оруулж тооцохгүй бөгөөд сургуулийн зүгээс төсөл, хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь ямар нэг байдлаар захиргааны дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхгүй.

Тав. Бусад

5.1. Журмын хэрэгжилт, зохион байгуулалт, хяналтыг Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс (ЭШИХ) хариуцан явуулна.

5.2. Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулах эсэхийг ЭШИХ-ийн саналыг үндэслэн МУИС-ийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.